

АРДЧИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИК

МОНГОЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ХУВЬСАЛ
ӨӨРЧЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДАЛ

周光辉 ZHOU GUANG HUI

БНХАУ-ын Жилиний Их Сургуулийн Төрийн Захиргааны Удирдлагын Сургуулийн профессор, Жилийн Их Сургуулийн нийгмийн шударга ёс болон Загсийн газрын удирдлагын судалгааны төвийн захирал
中国, 现任吉林大学行政学院政治学专业教授, 吉林大学社会公正与政府治理研究中心主任

Д. ТҮМЭНЖАРГАЛ

БНХАУ-ын Жилин мужийн Жилиний Их Сургуулийн
Төрийн Захиргааны Удирдлагын Сургуулийн докторант

Түлхүүр үг: Ардчилал, ардчилсан сонгууль, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн мажоритар болон холимог тогтолцоо.

Товч утга: Монголын сонгуулийн тогтолцооны үүсэл болон УИХ-ын сонгууль болж өнгөрсөн үйл явц, УИХ-ын сонгуулиудыг явуулахад хэрэглэж ирсэн сонгуулийн тогтолцооны хэрэгжилт, Монгол орон ардчилалд шилжсэнээс хойших 20 гаруй жилийн хугацаанд УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн хурлыг сонгох бүх нийтийн сонгуулийг 17 удаа явуулж, 6 удаагийн парламентын (УИХ) сонгууль явуулсан байна. Тэдгээрээс 1990 оны АИХ-ын анхны чөлөөт ардчилсан сонгууль, 2012 оны УИХ-ын сонгуулиудыг эс тооцвол Монголын ихэнхи сонгууль олонхийн мажоритар тогтолцоогоор явагдсан учраас уг тогтолцоог голлон авч үзэх нь зүйтэй. Монгол улс сонгуулийн хэд хэдэн тогтолцоог туршиж үзсэн боловч төлөөллийн байгууллагыг сонгох, сонгогчдын саналыг илүү харгалзсан тогтолцоог сонгон авч тогтвортой хэрэглэх асуудал ихээхэн анхаарал татаж байна. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол улсад болж өнгөрсөн бүхий л сонгуулиудыг хамруулах боломжгүй учир зөвхөн УИХ-ын сонгуулийн жишээн дээр тулгуурласан.

Сүүлийн үед Монголын ардчилал, ардчилсан сонгуулийн үйл явц, улс төрийн үйл явц, сонгуулийн тогтолцоо болон улс төрийн намын тогтолцооны харилцан хамаарлын талаар гадаадын судлаачид анхаарал хандуулах болсон. Тухайлбал: ХБНГУ-ын эрдэмтэн Удо Б.Баркманн¹, Оросын судлаач П.Глуховский², Юлиана Петренко³, Александр Габуев⁴, Тимур Куприянов⁵ БНХАУ-ын судлаач 章平 Zhang ping⁶, 杨启如 Yang qi ru⁷, БНХАУ-ын ӨМӨЗО-ны судлаач 白音吉日嘎拉 Bai yang ji ri ga la⁸, нарыг дурьдаж болно.

¹Удо Б.Баркманн. "МАХН-ын улс төрийн өөрийн ойлголтын тухайд". Монгол улсын ШУА-ын ОУСХ. Герман : судалгаа, мэдээлэл. УБ., 2005. "Монгол дахь улс төрийн намууд ба ардчиллын үйл явц". УБ., 2005. "МАХН ардчилал геополитикийн шахаанд орсон нь" УБ., 2005, "Монгол улсын шилжилтийн үеийн улс төрийн намуудын үүрэг". УБ., 2006

²Глуховский П. "Монголын улс төрийн намуудын систем сонгуулийн ялгаатай тогтолцоонд хэрхэн хөгжих талаар эргэцүүлэл" УБ., 2002

³Юлиана Петренко. Долгий путь к демократии Монголия вчера и сегодня. Журнал о выборах. №4. 2013

⁴А.Габуев: На монгольских выборах использовали минеральный ресурс. Большинство в парламенте получила правящая партия. "Коммерсантъ", 1 июля. № 111(3928) от 01.07.2008. .

⁵Тимур Куприянов. Настоящая демократия – Монголия готовится к ключевым для страны выборам Международные отношения В мире 2012.01.29

⁶章平. 蒙古政党制度与演变发展趋势. 蒙古国研究. [J].中国蒙古国研究会, 呼和浩特: 1999 年.

Zhang ping (Жанпинь). "Монголын улс төрийн намын тогтолцоо болон өөрчлөлт хөгжлийн чиг хандлага". Монгол улсын судалгаа сэтгүүл. БНХАУ-ын Монгол улсын талаарх судалгааны нийгэмлэг. Хөх хот., 1999.

⁷杨启如. 蒙古 2000 年大选前的形势及发展走向. 蒙古国研究. [J].中国蒙古国研究会, 呼和浩特: 1999 年.

Yang qi ru (Янширу). "Монгол улсын 2000 оны УИХ-ын сонгуулийн өмнөх нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага". Монгол улсын судалгаа сэтгүүл. БНХАУ-ын Монгол улсын талаарх судалгааны нийгэмлэг.

Хөх хот., 1999.

⁸白音吉日嘎拉. 试论蒙古国的选举制度. 蒙古国研究. [J].中国蒙古国研究会, 呼和浩特: 1999 年.


Bai yan ji ri ga la (Баянжаргал). "Монгол улсын сонгуулийн тогтолцоо". Монгол улсын судалгаа сэтгүүл. БНХАУ-ын Монгол улсын талаарх судалгааны нийгэмлэг. Хөх хот., 1999.

1. Монголын сонгуулийн тогтолцооны үүсэл, хөгжил

Монголчууд эрт дээр үеэс хаанаа сонгож байсан боловч энэ нь зөвхөн алтан ургийнхны онцгой эрх байсан. Харин анхдугаар Үндсэн хууль 1924 онд батлагдсан нь Монгол Улсад сонгуулийн тогтолцоо бүрэлдэн тогтоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Уг хуульд Монгол оронд шинээр үүсэн бүрэлдэж байгаа сонгуулийн тогтолцоог сонгуулийн гол зарчим, зорилго, эрх зүйн зохицуулалтыг агуулсан “сонгох, сонгогдох эрхийн тухай” тусгай бүлэг болгон хуулиндаа тусгасан нь сонгуулийн үзэл санаа, хэрэглэх практик төлөвшихөд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Анхдугаар Үндсэн хуульд, БНМАУ-ын төрийн эрх барих байгууллага нь бүх шатны Ардын Хурал мөн бөгөөд эдгээр хурлуудыг байгуулж хууль ёсны болгох улс төрийн ажиллагааны хэлбэр нь Ардын Хурлын сонгууль байхыг тодорхойлж, сонгууль нь жил тутам тогтмол явагдаж байх, сонгуулийг олон шаттайгаар явуулах, сонгох, сонгогдох эрх эдлэх явдал анги ялгаварласан зарчимд тулгуурласан байхаар тогтоожээ. Хэдийгээр нийт ард иргэд үүний дотор эмэгтэйчүүд сонгуулийн эрхтэй болсон боловч бусдыг мөлжин амьдрагчид, худалдаачид, мөнгө хүүлэгчид, ван, гүн ба хутагт хувилгаад, тайж, лам зэрэг хүн амын нийлээдгүй хэсгийн сонгуулийн эрхийг хязгаарласнаар сонгуулийн тэгш эрхийн зарчим үгүйсгэгдсэн юм. 1940 оны Үндсэн хуулиар ангийн дайсан, хувьсгалын эсэргүү хэмээгдэх этгээдүүдийн сонгуулийн эрхийг нэмж хасчээ. Харин 1949 оны Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн хуучин тогтолцоог халж, нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчимд тулгуурласан сонгуулийн шинэ, дэвшилтэт тогтолцоонд шилжсэн билээ⁹. 1950-1990 онд сонгуулийн уг тогтолцоогоор Ардын Их Хурлын сонгууль 12 удаа, орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын сонгууль 65 удаа тус тус явагдсан юм. Сонгууль тогтворжсон боловч чөлөөт биш, ёс төдий байж, тухайн нийгэмд тогтсон нэг намын дэглэм, захиран тушаах тогтолцоонд үйлчлэх үүрэгтэй байснаас ардчилсан шинжийг бүрмөсөн гэж, гагцхүү “нам, нам бусчуудын ган бат нэгдэл”-ийн илэрхийлэл болон хувирчээ.

Схем № 1. Монгол дахь сонгуулийн тогтолцооны үүсэл хөгжил



Вай уан жи ги га ла (Баянжаргал). “Монгол улсын сонгуулийн тогтолцоо”. Монгол улсын судалгаа сэтгүүд. БНХАУ-ын Монгол улсын талаарх судалгааны нийгэмлэг. Хөх хот., 1999.

⁹ И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ., 1975

Схем № 2.

Үүсэл хөгжлийн үе шат

Монгол улс 1930 оныг дуусталх хугацаанд арван гэрийн хурлаас багийн хурлын төлөөлөгчид, сумын хурлаас хошууны хурлын төлөөлөгчдийг, хошууны хурлаас аймгийн хурлын төлөөлөгчдийг, аймаг хотын хурлаас Улсын их хурлын төлөөлөгчдийг сонгож байв.

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуульд Улсын Их хурал ба аймаг, хот, сум, хорооны хурлуудыг тус тус доод хурлаас сонгогдсон төлөөлөгчдийг сонгож байсан. БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 70-р зүйлд “Засаг захиргааны бүхий л байгууллагуудыг хурал дээр нь ил сонгуулиар гүйцэтгэнэ” гэж сонгуулийн ардчилсан тогтолцооны үндсэн зарчмыг бататгасан байна.

1949 оны 2 дугаар сард улсын IX их хуралд “БНМАУ-ын сонгуулийн тогтолцооны ардчиллыг цаашид улам хөгжүүлэх тухай” асуудлыг авч хэлэлцээд сонгуулийн тогтолцооны талаар тус улсын Үндсэн хуульд оруулан өөрчлөн баталжээ. Үндсэн хуулийн 9-р бүлэгт “БНМАУ-ын сонгуулийн систем” гэж нэрлээд уг Үндсэн хуулийн 80-87-р зүйлд зааж өгсөн. Үүнд төлөөлөгчдийн хурлыг шууд сонгуулиар бүх нийтээрээ тэгш эрхтэй оролцох үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгон байгуулах, сонгуулийн шинэ тогтолцооны дагуу сонгогчид нь төрийн эрх барих байгууллагын ямар ч дамжлагагүй шууд сонгон эрхтэй болсон.

2. Монголын УИХ-ын сонгуулийн тогтолцооны үйл явц

Аливаа ардчилсан нийгмийн нэг гол шинж нь төрийн тогтолцоог төлөвшүүлэхдээ чөлөөтэй бөгөөд шударга сонгуулийг тогтмол явуулах явдал байдаг. Үүний үндэс нь засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх, иргэд сонгуульд нийтээрээ, чөлөөтэй оролцож, төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага болон төрийн тэргүүнийг тодорхой хугацаагаар¹⁰ сонгож байх үндсэн хуулийн зарчмууд юм. Сонгууль ёс төдий, хэлбэрдсэн зүйл байж болохгүй. Учир нь түүний үр дүнд ард түмний шууд биечлэн оролцоотойгоор төрийн эрх барих дээд байгууллага бий болж улмаар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага байгуулагддаг юм. Ардчилсан нийгэмд сонгууль өргөн олныг хамарсан, бүх нийтийн шинжтэй байна. Өөрөөр хэлбэл сонгуулийн насанд хүрсэн иргэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр сонгуульд чөлөөтэй оролцох нөхцөл бололцоогоор хангагдсан байх учиртай.¹¹

1990 оноос Монголын ард түмэн ардчилсан аргаар төр барих эрхээ жинхэнэ утгаар нь эдлэх болсон. 1992 оны Үндсэн хуулийн 3-р зүйлд “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ”¹² гэж заасан байна. 1990 оноос улс төрийн амьдралд гарсан өөрчлөлт, шинэчлэлтэй уялдан сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгож шинэчлэх, жинхэнэ утгаар ардчиллын үндсэн хэрэгсэл болгон ашиглах

¹⁰ Сонгуулийг явуулах хугацааг хуулиар тогтооно. Дэлхийн практикт нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хугацаа нь 4-5 жил байдаг бөгөөд ийм хугацаагаар парламент, ерөнхийлөгч болон төрийн бусад албан тушаалтан сонгогддог. Заримдаа түүнээс урт францын ерөнхийлөгч 7 жил байсан, эсхүл богино латвийн ерөнхийлөгч 3 жил, Швейцарийн ерөнхийлөгч 1 жил, АНУ-ын Конгрессын төлөөлөгчдийн танхимын гишүүн 2 жил хугацаагаар сонгогдож болно. Харин төрийн захиргааны албан хаагч болон шүүгчдийг хугацаагүй томилдог.

¹¹ Хилийн чанадад байгаа иргэддээ бүх нийтийн сонгуульд санал өгөх бололцоо олгох нь шийдвэрлэхэд бэрхтэй асуудал мөн. Үүнийг улс орнууд харилцан адилгүй шийдвэрлэж байна. Дийлэнх орон уг асуудлыг зохицуулдаггүй бол зарим орон гадаадад байгаа иргэдэд сонгуульд оролцох эрхийг нь хангаж өгдөг. Тухайлбал 1979 онд Тунис, 1985 онд ХБНГУ, 1989 онд Исланд, 1991 онд Швейцар ийм алхам хийсэн болно. Үүнийг шийдвэрлэх арга зам харилцан адилгүй байдаг. Жишээ нь гадаадад байгаа Швейцарийн иргэд шуудангаар саналаа өгөх боломжтой байдаг бол Итали, Орос зэрэг зарим орон хилийн чанадад сонгуулийн тойрог байгуулдаг.

¹² Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.

алхмуудыг хийж эхэлсний үр дүнд Монгол Улс түүхэндээ анх удаа Ардын Их Хурлаа сонгуулиар байгуулсан. Уг сонгууль нь холимог тогтолцоогоор явагдаж улс төрийн олон намууд анх удаа өрсөлдөн оролцсон шинэ, чөлөөт сонгууль болж өнгөрсөн хэдий ч энэхүү ардчилсан сонгууль нь зөвхөн хэлбэрийн төдий л байсан бөгөөд АИХ-ын танхим нь цөөн намуудын эвлээс бүрдэж байсан. (намын өнгөрсөн түүх болон шилжилтийн цаг үеийн байдалтай харьцуулан үзэх нь зүйтэй) Монгол Ардын Хувьсгалт Нам нь орон нутгийн төлөөллийг сонгоход 53.4%, АИХ-ыг сонгох сонгуулиар нийт 84.8%-ийн саналыг авч байсан. Ингэж МАХН Монгол улсын парламентын нийт 422 суудлын 357 суудлыг авч чадсан. Харин МАН 16 суудал, МҮДН 6 суудал, МСДН 4 суудал тус тус эзэлсэн бөгөөд үлдсэн суудлыг гишүүн бусчууд, залуучуудын холбооны нэр дэвшигчид эзэлсэн. Олон намын төлөөлөл оролцсон түүхэндээ анхны сонгууль гэхэд сөрөг хүчнийхэн чамлахааргүй амжилтанд хүрсэн юм.¹³ 1990 оны анхны АИХ-ын сонгууль, 1992, 1996 оны УИХ-ын сонгуулиудын үйл явц нь шилжилтийн эхэн үеийн бэрхшээл, нийгмийн соёл, ухамсрын төлөвшөөгүй байдал, ардчилсан сонгуулийн туршлага дутмаг зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж зарим нэг зөрчилтэй асуудлууд урган гарч ирж байсан. Монгол улсын судлаачид энэхүү гажуудал нь сонгуулийн тогтолцооны төлөвшилтийн шилжилтийн үеийн бэрхшээлтэй асуудлуудтай холбоотой байсан гэж үзсэн.

Монгол улсын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа хууль тогтоох дээд байгууллага 1992 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, 1993 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, орон нутгийн сонгуулийн хуулийг батлан гаргасан. Эдгээр хуулиудын дагуу Монголчууд төрийн дээд байгууллагаа шууд, чөлөөтэй, ардчилсан зарчмаар сонгон хэрэгжүүлсэн бөгөөд Монгол улсын иргэд сонгох, сонгогдох эрхээ тэгш эдэлж, сонгуульд чөлөөтэй оролцож, ухамсартай сонголт хийх бололцоо бүрдсэн өгсөн. 1992 онд батлагсан УИХ-ын сонгуулийн хуулийн дагуу олон мандаттай мажоритар тогтолцоогоор томгосон тойргоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь нэг намын олонхиос бүрдэж байсан. УИХ-ын сонгуулийн гол ач холбогдол нь түүхэндээ анх удаа ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, түүгээрээ хүний эрх, эрх чөлөө, ардчилсан чөлөөт сонгуулийг хуульчлан баталгаажуулж, сонгуулийн тухай хуулийг баталж, нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд шилжин, ард түмэнд сонгох олон хувилбар, боломжийг олгосонд төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага Ардын Их Хурлыг сонгосон юм. Сонгуулиар байгуулагдсан БНМАУ-ын Ардын Их Хурал 1991, 1992 оныг дамжин хуралдаж, 1992 оны 1 дүгээр сарын 13-нд Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталж Тэрхүү хуулиндаа сонгуулийн эрх, эрх чөлөө, сонгох, сонгогдох эрхийг тусгаж өгсөн. Мөн зах зээлийн эдийн засаг, өмчийн олон хэлбэр, улс төрийн ардчилал, оюун санаа, үзэл суртлын олон ургальч байдалд тулгуурласан шинэ нийгмийг байгуулах эхлэлийг тависан бөгөөд энэ сонгуулиар 8 нам, 2 эвсэл сонгуульд өрсөлдөн, нам эвслээс 275 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч 18 хүн өрсөлдөж нийт нэр дэвшигчид нь 293-д хүрсэн нь Монголын улс төрийн амьдралд ард түмний хувьд улс төрийн цоо шинэ үзэгдэл болсон бөгөөд уг сонгуулиар МАХН дангаараа УИХ-д 70 суудалч авч ялалт байгуулсан. Мөн түүнчлэн нийт сонгогчдын 95,6 хувь нь оролцсон идэвхитэй анхны ардчилсан чөлөөт сонгууль болж байснаараа чухал ач холбогдолтой. Анхны энэ сонгуульд салбарын тэгш эрхийн зарчмыг ноцтой зөрчсөн, мөн сонгуулийн дүнг гаргахад ч бэрхшээлтэй асуудлууд үүсгэж байсан гэх мэт нилээдтэй алдаа дутагдал байгааг дурдахаас гадна энэ нь салбарын тогтолцоог боловсонгүй болгох зайлшгүй шаардлагатай хэмээн Монголын судлаачид үзэж байсан¹⁴.

1990 оны УИХ-ын сонгууль нь 1995 онд сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, олонхи/нийгмийн тогтолцооны сонгодог хувилбар болох нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдах УИХ-ын сонгууль болж мөн намын эвлээс бүрдэж байсан юм. Сонгуулийн хуульд 1995, 1996 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж энэ хуулийндагуу УИХ-ын сонгуульд 5 нам, 2 эвсэл, нам эвслээс 267 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч 35 нэр дэвшигч сонгуульд оролцсон ба нийт тоогоор 302 нэр

¹³ Удо, Баркманн. "МАХН-ын улс төрийн өөрчлөлтүүд" *Монгол Улсын Их Хурлын 10 жилийн тунгав* I сөрмөн судалгаа, мэдээлэл. УБ., 2005

¹⁴ Б.Чимэд. Сонгуульд суралцахуй. *Логотестөө, үйл явц, эрх зүй*. УБ., 2008

дэвшигч сонгуульд оролцож өрсөлдсөн баримт бий. Энэ удаагийн сонгуульд оролцсон нэр дэвшигч 1992 онтой харьцуулахад нэр сонгуульд нэр дэвшигчид нь бие дааж нэр дэвшсэн 17 хүнээр нэмэгдсэн бөгөөд нам эвслээс нэр дэвшсэн 8 нэр дэвшигчээр багассан. 1996 оны сонгуульд оролцсон сонгогчдын ирц 92.1% буюу урьд оныхоос 3.5 %-иар сонгогчдын идэвхи нь буурсан. Уг сонгуулиар “Ардчилсан холбоо” эвсэл УИХ-д 50 суудал авч ялалт байгуулж Монгол улсад анх удаа Засгийн газрын эрх ардчилсан сонгуулийн зарчмаар, тайван замаар нэг улс төрийн хүчнээс нөгөө улс төрийн хүчинд шилжсэнээрээ онцлогтой.

2000 оны УИХ-ын сонгууль нь нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь нэг намын олонхиос бүрдэж байв. Энэ удаагийн сонгууль нь өмнөх сонгуулиудаас хамгийн олон нам эвсэл сонгуульд оролцсон гэж үздэг нийт 13 нам, 3 эвсэл сонгуульд оролцож, нам эвслээс 575, Бие дааж 27 хүн нийт 602 хүн нэрээ дэвшүүлж өрсөлдсөн ба сонгуульд нийт сонгогчдын 82.4% нь оролцож саналаа өгсөн. Энэ сонгуулиар МАХН 76 суудлын 72 суудлыг авч дахин төрийн эрхийг барих болсон.

2004 оны УИХ-ын сонгууль нь нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь хамгийн ойр байр суурьтай намын эвлээс бүрдэж байсан юм. Энэ сонгуулиар Нийт 7 нам, 1 эвсэл сонгуульд оролцож, нам эвслээс 229 нэр дэвшигч, 15 бие даан нэр дэвшигчид сонгуульд оролцож нийт нэр дэвшигчдийн тоо 244 байсан. Сонгогчдын 82,2 хувь санал өгсөн ба¹⁵ сонгуулийн дүн гарахад Ардчилсан хүчин болон МАХН хоёр тэгш тооны санал авсан бөгөөд түүхэндээ анх удаа их эвслийн Засгийн газар байгуулсан улс төрийн хоёр том хүчин тэнцсэн¹⁶. Уг сонгуулийн үр дүнд бие даагч-3, МАХН-35, АН, ИЗН, МАШСН “Эх орон эвсэл” -38 суудлыг тус тус авсан юм.

1992, 1996, 2000 онд болж өнгөрсөн Монголын парламентын ээлжит сонгуулиуд нь шилжилтийн үеийн өвөрмөц бэрхшээлтэй үед явагдсан бөгөөд тухайн сонгуульд оролцож байсан улс төрийн субъект, улс төрийн нам хүчин, электоратын төлөвшил, сонгуулийн кампани зохион байгуулах арга нь дутуу, сонгуульд бохир технологи хэрэглэсэн, эрх зүйн орчин нь сайн бүрдээгүй зэрэг хүчин зүйлүүдтэй ихээхэн холбоотой.

2008 оны УИХ-ын сонгууль нь олон мандаттай мажоритар тогтолцоогоор томсгосон тойргоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь хамгийн цөөн намуудын эвслээс бүрдэж байсан. Энэ үеийн сонгуульд 311 нэр дэвшигчид, 11 улс төрийн нам хүчин эвслээс, 45 бие даагч нэрээ дэвшүүлсэн гэсэн статистик тоо баримт байдаг. Монгол Ардын Хувьсгалт Нам болон Ардчилсан нам хоёулаа сонгуульд ялахын тулд бэлэн мөнгийг (1.000.000 төг, 1.500.000 төг) сонгуулийн кампанит ажлын үеэр амлацгаасан. Олон улсын 16 сэтгүүлч сурвалжлагчид уг сонгуулийн процессийг ажиглан өөрийн эх орондоо түргэн шуурхай мэдээлж байсан бөгөөд ихэнхи сэтгүүлчид сонгууль ил тод, чөлөөтэй, шударга болж өндөрлөө гэж дүгнэсэн. Сонгуулийн үр дүн нь Монгол ардын хувьсгалт нам УИХ-ын 45 суудлыг, Ардчилсан нам УИХ-ын 28 суудлыг, бие даагч 1 суудлыг, Иргэний эвслээс 1 суудлыг, Иргэний зориг намаас 1 суудал тус тус эзэлсэн. 2008 оны сонгуулийн дүн хэдийгээр гарсан ч сонгууль шударга явагдаагүй, санал хураалт болон санал тоолох ажиллагааг луйвардсан, олон тооны иргэний үнэмлэх хуурамчаар үйлдэж санал өгүүлсэн, иргэний үнэмлэх дээрх хаягийн бүртгэлийг сольж, санал давхардуулж өгүүлснээс иргэдийн иргэний зөв сонголт гараагүй, Ардчилсан нам Монгол Ардын Хувьсгалт намыг сонгуулийг будлиантуулж сонгогчдын саналыг луйвардсан гэж үзсэн. 2008 оны 07-р сарын 01-нд МАХН-ын байрны урд жагсагчид цуглан эмх замбараагүй байдал үүсгэсэн. Үүний үр дүнд 220 жирийн иргэн, 108 цагдаа болон хамгаалалтын ажилтнууд гэмтэж бэртэж 5 хүн харамсалтайгаар амь насаа алдсан. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд “Монгол улсын иргэн амьд явах эрхтэй” гэж заасныг зөрчсөн үйл явдал болсон.¹⁷ Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 4 өдрийн онцгой байдал зарласан. 2008 онд УИХ-ын сонгуульд “ялагч бүхнийг авна” гэсэн зарчимтай уламжлалт мажоритар тогтолцоогоо томсгосон тойрог, олон мандатаар баяжуулж хэрэгжүүлсэн нь намууд хоорондын

¹⁵ “Ардчилсан төрийн сонгуулийн товчоон” СЕХ.УБ., 2005

¹⁶ Монгол улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. Монгол улсын ШУА, ФСЭХ. УБ., 2000

¹⁷ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

төдийгүй, нам доторх өрсөлдөөнийг бий болгосон бөгөөд олон хүний амь насанд хүрсэн, нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэж гэмт хэргийг дэвэргэсэн, соёлын болон түүхийн дахин давтагдашгүй бүтээлээ устгасан, Монгол улсын улс орны эдийн засагт сөргөөр нөлөөдсөн, ардчиллын зарчмыг гажуудуулсан сонгууль болж өнгөрсөн.

2012 оны УИХ-ын сонгууль нь шинэ эрх зүйн зохицуулалтын хүрээнд, сонгуулийн холимог тогтолцоогоор, нийт 11 нам, 2 эвсэл, нийт 544 нэр дэвшигч өрсөлдсөн ба үүнээс эмэгтэй нэр дэвшигч 174, бие даан нэр дэвшигч 26 өрсөлдсөн байна. Мөн гадаадад суугаа Монгол улсын иргэдээ сонгуульд оролцуулсан, ухаалаг үнэмлэхтэй, санал тоолох автомат машиныг ашигласан зэрэг нь өмнөх сонгуулиудад онцлогтой болж өнгөрсөн. Автомат санал тоолох машины тусламжтайгаар сонгууль явуулсан нь нэг талдаа сонгуулийн дүнг гаргахад хугацааны хувьд хурдан шуурхай байсан хэдий ч нөгөө талдаа хүчингүй саналын хуудас байхгүй 100% сонгогчдын санал хүчинтэй гэсэн дүн гарсан нь эргэлзээ төрүүлж байгаа юм. Монголын сонгогчдын оролцоо 2012 оны сонгуульд 67.28 хувь буюу 1238537 сонгогч оролцож саналаа өгсөн нь жилээс жил сонгогчдын оролцоо нь буурч байгааг дахин харуулж байна. Энэ нь Монголын нийгэмд гүн шигдэж орсон авилгал хүнд суртал, ядуурал, сонгогчдол сонголтлоо хийхэд нь саад дарамт болдог гэж үзэж болно.

Мөн сонгуулийн дүн автомат санал тоолох машины тусламжтай хурдан шуурхай гарсан гэх боловч зарим тойрогт маргаан гарч удааширсаар байсан нь Монголын сонгогчдын сонгуульд оролцох идэвхийг бууруулсан.

3. Монголын сонгуулийн тогтолцооны хэрэгжилт

Монгол улс ардчилалд шилжсэнээс хойших 20 гаруй жилийн хугацаанд УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлыг сонгох бүх нийтийн сонгуулийг 17 удаа явуулж сонгуулийн хэд хэдэн тогтолцоог туршиж үзсэн боловч төлөөллийн байгууллагыг сонгох, сонгогчдын саналыг илүү харгалзсан тогтолцоог сонгон авч тогтвортой хэрэглэх асуудалд ихээхэн анхаарч байна. Парламентын 6 удаагийн сонгууль явуулж байгаа сонгуулийн тогтолцоонууд, эрх зүй орчин, бусад хүчин зүйлүүдээс нөлөөлөн эерэг, сөрөг үр дагаврын талаар авч үзвэл:

Монгол улсад явагдсан парламентын 6 удаагийн сонгуулийн үр дүнд нэг намын олонхийн танхим хоёр удаа (1992, 2000 он), эвслийн танхим 5 удаа (1990, 1996, 2004, 2008, 2012 он) бүрэлдсэн байна. Монгол улсын одоогийн засгийн газрын танхимыг “хамгийн цөөн намуудын эвсэл”-ийн хэв шинжид багтаан үзэж болно. Эвслийн энэ хэв шинжийг судлаач Майкл Лейсерсон “хэлэлцэн тохиролцох”-д суурилсан эвсэл гэж нэрлэсэн¹⁸.

Хүснэгт № 1. Монгол улсын парламентын намуудын тооны харьцааг харуулбал¹⁹

Онууд	Сонгуулийн тогтолцоо	Тоон хэв шинж
1996, 2000, 2008	Харьцангуй ба нэг мандаттай мажоритар тогтолцоо	Бүтээмэл олонхи
1992		Бодит олонхи
2004	Хувь тэнцүүлсэн тогтолцоо	Бодит цөөнх
1990, 2012	Холимог тогтолцоо	Бүтээмэл олонхи

¹⁸Эх сурвалж: Г.Чулуунбаатар, А.Жамбал, Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрүүдийн үйлчлэл, үр дагаврын асуудал. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Илтгэлийн эмхтгэл. УБ., 2009

¹⁹Эх сурвалж: Г.Чулуунбаатар, А.Жамбал, Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрүүдийн үйлчлэл, үр дагаврын асуудал. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Илтгэлийн эмхтгэлээс эх сурвалж. УБ., 2009

Сонгуулийн тогтолцооны парламентын намын тоонд нөлөөлөх нөлөөллийн үр дүнг хэмжих гол хэмжүүр нь парламент дахь намуудын “үр ашигтай тоо” юм. Сонгуулийн тогтолцоо Дуглас, В.Райн нарын тооцоолсоноор бүгд парламентын “бүтээмэл олонхи”-ийг бий болгох бололцоотой хэдий ч сонгуулийн харьцангуй болон нэг мандаттай мажоритар тогтолцоо гол төлөв бүтээмэл болон бодит олонхийг, харин пропорциональ тогтолцоо нь бодит цөөнхийг бий болгодог байна.. Монгол улсын хувьд сонгуулийн олонхийн мажоритар тогтолцоо зонхилон үйлчилж байсантай уялдан тус оронд гол төлөв бүтээмэл болон бодит олонхи (бодит олонхи /1992,/ бүтээмэл олонхи /1996, 2000 /) бүрэлдэж байсан. Харин 2004 онд бодит цөөнх бүрэлдэж байв.

Хүснэгт № 2.

УИХ-д олонхи болж, Засгийн газрыг дангаараа бүрдүүлсэн нам, эвслийн сонгуульд авсан санал, парламентад эзэлсэн суудлын хувийн харьцуулалт (Сонгуулийн жилээр)²⁰

Сонгууль болсон он	Оролцсон нам эвслийн нэр (тоо)	Авсан суудлын тоо	Нийт тойргийн хэмжээ
1992	• МСДН	1	26
	• Бидаагч	1	
	• МоАН, МүДН,НН	4	
	• МАХН	70	
1996	• МУНН	1	76
	• МАХН	25	
	• АХ эвсэл	50	
2000	• ИЗ-НН эвсэл	1	76
	• Эхорон МАШСН	1	
	• Бидаагч	1	
	• АХ эвсэл	1	
	• МАХН	72	
2004	• Бидаагч	3	76
	• МАХН	35	
	• АН, ИЗН, МАШСН-“Эхорон-Ардчилал” эвсэл	38	
2008	• Бидаагч		26
	• АН		
	• ИЗН		
	• ИЭН		
2012	• АН		26
	• МАН		
	• МАХН-МҮАН шударга ёс эвсэл		
	• ИЗН, Ногоон нам		
	• Бие даагч		

Сонгуульд оролцсон нам, эвслийн байдлыг харвал 1992 оноос хойших УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс ажиглахад Монгол улс олон намын тогтолцоотой, сонголт хийх боломжоор бүрэн хангагдсан орон болох нь харагдаж байна. Мөн сүүлийн хэдэн сонгуулийн дүнгээс харахад намууд хоорондоо эвсэж эвсэл болон оролцох хандлагатай байна. Монголын улс төрийн намууд хоорондоо эвсэж байгаа нь сонгогчдод сонгох альтернатив боломжийг олгох, намууд төлөвших, намуудын улс төрийн оролцоо нэмэгдэх зэрэгт эерэг талтай ч байж болох юм.

Хэдийгээр 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газрын танхим нь онолын хувьд стандарт бус шийдвэрт тулгуурласан нь үнэн боловч улс төрийн амьдралын практикаас үзэхэд нэг бус удаа тохиолдож байсан хэв шинж юм байна.

²⁰ Сонгуулийн Ерөнхий Хорооны тоо баримтаас иш татав. УБ., 2012

Хүснэгт № 3. Монгол дахь засгийн газрын танхимын бүрдэлтийн харьцаа²¹

Он	Сонгуулийн тогтолцоо	Засгийн газрын танхим	Засгийн газар бүрдүүлсэн нам. эвсэл
1990	Хөдөлмөг	Хамгийн цөөн намуудын эвсэл	МАХН болон МАН,МҮДН, МСДН
1992	Олон мандаттай мажоритар	Нэг намын олонхи	МАХН
1996	Нэг мандаттай мажоритар	Олон намын эвсэл	АХ эвсэл
2000	Нэг мандаттай мажоритар	Нэг намын олонхи	МАХН
2004	Нэг мандаттай мажоритар	Хамгийн ойр байр суурьтай намын эвсэл	"Эх орон- ардчилал" эвсэл
2008	Олон мандаттай мажоритар	Хамгийн цөөн намуудын эвсэл	МАХН
2012	Хөдөлмөг	Олон намуудын эвсэл	АН, МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл

Монголын дийлэнхи сонгуулиудад үйлчилж ирсэн харьцангуй мажоритар тогтолцоогоор Засгийн газар нь 1996-онд анх солигдсон бөгөөд 2000 онд мөн Засгийн газар нь солигдож байсан. Сонгуульд санал өгсөн сонгогчдын дүнгийн харьцаа харилцан адилгүй маш зөрүүтэй тухайлбал: 2000 оны сонгуулиар саналын 50% орчим авсан эрх баригч нам УИХ-ын 76 суудлын 72 суудлыг авч байсан байна.

Ардчилал бэхжсэн орнууд ч өөрийн орны дотоодод бүрэлдсэн улс төрийн нөхцөл байдлаас хамаарч сонгуулийн реформыг хийсээр ирсэн байдаг. Япон мажоритараас холимог тогтолцоонд, Итали пропорционалаас мажоритар тогтолцоонд, Унгар холимогоос мажоритар тогтолцоонд шилжсэн бол Франц 1980-аад оны дундуур мажоритараас пропорциональд шилжиж нэг сонгуулийн дараа дахин мажоритар тогтолцоогоо сэргээн хэрэглэсэн байх жишээтэй. Үүнээс үзэхэд сонгуулийн хамгийн шударга тогтолцоо, хамгийн шударга хувилбарыг сонгоно гэдэг бол харьцангуй ойлголт юм. Сонгогч бүрийн саналыг тусгах талаар пропорциональ тогтолцоо давуутай, илүү олон санал авсан хүн сонгогддог мажоритар тогтолцоо шударга. Сонгуулийн тогтолцоог сонгон авах суурь үндэслэл нь тухайн үндэстний түүхэн хөгжил, нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөр нөхцөлдөж бий болсон нийгмийн бүтэц, улс төрийн уламжлал, менталитет, засаг захиргааны зохион байгуулалт, улмаар газар нутаг, хүн амын хүчин зүйлс байх учиртай. Энэ утгаар ихэнхи сонгуулиудад хэрэглэгдэж байсан мажоритар тогтолцоо Монголд илүү тохирох талтай. Гэхдээ энэ нь уг тогтолцооны сөрөг үр дагавар болсон нийгмийн төлөөлөл хангалтгүй тусгагддаг, сонгогчдын санал гээгддэг дутагдлыг арилгах арга замыг тооцох хэрэгтэй.

Монголд хэрэгжиж ирсэн сонгуулийн мажоритар тогтолцооны бас нэг дутагдалтай тал нь сонгууль явуулахад сонгогчдын санал маш ихээр гээгддэг. Тухайлбал: 1992 оны Монгол улсын УИХ-ын сонгуульд сонгогчдын 60% орчмын төлөөлөл хангагдаж 40% орчим төлөөлөл орхигдсон. 2000 оны сонгуулиар сонгогчдын бараг тал хувийн саналыг орхигдуулж байсан. Харин хувь тэнцүүлэх тогтолцооны үед намууд ч, сонгогчид ч хохирох нь бага байдаг. Монгол улс нэг танхимтай, орон нутгийн бие даасан байдал сул, үндэсний ашиг сонирхлын хүчтэй ялгарал багатай хувьд сонгуулийн мажоритар тогтолцоо төднийлөн оновчтой байж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Монгол улсад мөрдөгдөж буй сонгуулийн тогтолцоонд сонгогчид улс төрийн намд санал өгч, парламент нь олон намаас бүрэлддэг учраас аль нэг нам хэт олонхийн суудал авч, улс төрийн нам нь дотоодод авилгалд автах магадлалтай. Мөн хэвлэл мэдээлэлд дангаар монополь эрх тогтоох боломж олгож байна. Гэхдээ энэ намын дотоод асуудлыг намын дотоод ардчилал, зохион байгуулалтын байдлаар өөрчлөх боломж бий хэмээн Монголын зарим судалгаа шинжилгээний бүтээлүүдэд дурьдсан байдаг.

Сонгуулийн мажоритар тогтолцоогоор сонгогдсон УИХ-ын гишүүд нийт улс орны ашиг сонирхлыг төлөөлөхөөс гадна өөрийн нам болон тойргийн сонгогчдын хүсэл зорилгыг илэрхийлдэг учраас

²¹ Эх сурвалж: Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик /Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ., 2009 он

үүнээс болж парламентат ёсны нийтлэг зарчим алдагдах, үзэл бодол, байр суурь зөрчилдөх зэрэг сөрөг байдлыг бий болгодог. Мажоритар тогтолцоо нь Монголын сонгогчдод нам, намын мөрийн хөтөлбөр гэхээсээ илүү тухайн намаас нэр дэвшиж буй хувь хүнийг, нэр дэвшигчийг илүүд үзэх, сонгогчдын нам ч бус сэтгэл зүйг бий болгох сөрөг үр дагавартай байж болох юм. Мөн энэ тогтолцоо нь Монголын хоёр том намыг сонгогчдод дасгаж, олон жижиг намуудыг үл ойшоох хандлагыг бий болгож байдаг.²²

Монгол улсын сонгогчид тойргоо солих, танил тал, ах дүү, хамаатан садан, байгууллагын ажилчдынхаа тойргийг зохион байгуулалттай солих явдал сонгуулийн үед гарсан хамгийн томоохон зөрчил бөгөөд энэхүү зөрчил нь цаашид даамжирвал сонгуулийн дүнд сөргөөр нөлөөлж, сонгуулийн шударга зарчим алдагдах магадлалтай.

Монгол улсад хэрэгжиж ирсэн нэг мандаттай олонхийн мажоритар тогтолцоо нь сонгогчдод энгийн ойлгомжтой учраас сонгууль болж өнгөрсний дараа сонгуулийн үр дүнд эргэлзэх, төөрөлдөх зүйл гардаггүй, ихэнх сонгогчид сонгуулийн дүн хэрхэн гарах, хэнийг ялагч гэж тооцохыг мэдэж байдаг тул тэдний зүгээс сонголтоо хийхэд дөхөмтэй байдаг. Нөгөө талаас энэ тогтолцоо нь тойрог бүрт ширүүн өрсөлдөөнтэй явагддаг учраас сонгогчдын улс төрийн сонирхлыг сэргээж идэвхийг нь өрнүүлдэг. Ингэснээрээ сонгуулийн дараа шинээр бүрдсэн засгийн газарт тавих сонгогчдын хяналтыг сайжруулдаг байна.

Мөн Монголын сонгогчид улс төрийн намыг нэр дэвшигчээр нь үнэлж, саналаа өгч ирсэн дадал, уламжлалд өнөөгийн сонгуулийн тогтолцоо ихэд нийцдэг гэж Монголын судлаачид үздэг.²³ Энэ парламентын гишүүн болон түүний сонгогдсон тойргийн сонгогчдын хооронд тогтвортой холбоо, хариуцлагын тогтолцоог бий болгодог. Энэ тогтолцооны үед парламентын гишүүн нь зөвхөн улс төрийн намыг төлөөлөх бус харин өөрийн сонгогдсон тойргийн иргэдийг мөн төлөөлөх болдог. Тухайн гишүүн аль нэгэн тойргоос сонгогдохын тулд тэр тойргийн иргэдийн эрх ашиг, шаардлагыг парламентад уламжлах, хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэгт нь сонгогчдод нийцтэй байдаг.

Төрийн байгууламж, төрийн засаглалын хэлбэрийг үндэс болгож тийм улс заавал ийм тогтолцоог сонгож авах ёстой гэсэн хатуу дүрэм журам байдаггүй ч сонгуулийн тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох нь намын тогтолцоо, парламентын үйл ажиллагааны зарчимтай шууд уялддаг учир дураар шийддэг асуудал биш. Мажоритар тогтолцоо өнөөгийн Монголын улс төрийн сонирхлын олон талт байдалд бэрхшээлийг дагуулж байна.

Гэхдээ Монгол улс УИХ-ын сонгуулийг хамгийн энгийн, ойлгомжтой энэхүү тогтолцоогоор явуулж нилээдгүй туршлага хуримтлуулсан гэж хэлж болно.

Монгол улс УИХ-ын сонгуулийн хуульдаа 1996 оны 1-р сард уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд түүнээс хойш 2005 оны 12-р сарын 29-ний өдөр, 2006 оны 06-р сарын 16-ны өдөр, 2007 оны 12-р сарын 26-ны өдөр, 2008 оны 05-р сарын 22-ний өдөр, 2008 оны 12-р сарын 29-ний өдөр, 2009 оны 07-р сарын 03-ний өдөр, 2010 оны 02-р сарын 04-ний өдөр, 2011 оны 12-р сарын 15 -ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 1990 оны парламентын сонгууль мажоритар тогтолцооны тусгай зарчмыг голлосон холимог хэлбэрээр, 1992 оны УИХ-ын сонгууль олон мандаттай мажоритар тогтолцоогоор, 1996, 2000, 2004, 2008 оны УИХ-ын сонгууль нэг мандаттай мажоритар тогтолцоогоор, 1993, 1997, 2001, 2005, 2009, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиуд мажоритар тогтолцоогоор, 2012 оны УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор тус тус явуулахаар хуульчлан заасан дагуу явагдсан²⁴. Үүнээс үзэхэд Монголын сонгуулиудын ихэнхи нь мажоритар тогтолцоогоор явагдсан нь харагдаж байна.

Монгол улс 2011 онд сонгуулийн хуулиндаа өөрчлөлт оруулж шинэ тогтолцоогоор буюу 2012 оны УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсан ч сонгуулийн зарим тойрогт сонгуулийн дүн будлиантаж удаан хугацаагаар үргэлжилсний эцэст шүүхээр шийдэгдсэн гэх мэт сонгуультай холбоотой зарим зөрчил, маргаан хэвээр байсаар байна. Мөн 2012 оны УИХ-ын сонгуулийг явуулахдаа санал тоолох автомат машин ашигласны үр дүнд Монголын сонгогчид хүчингүй саналын хуудас байхгүй 100 хувь сонгуулиа өгч чадсан гэсэн дүн гарсан нь ихээхэн эргэлзээтэй юм. Сонгуулийн хуулийг сонгогчдод тайлбарлан таниулах тал дээр холбогдох байгууллагууд анхаарал хандуулж, ажилласан ч байж магадгүй. Гэхдээ л энэ дүн судлаачдын дунд нилээд эргэлзээтэй, анхаарал татсан

²² Д.Болд-Эрдэнэ. Монгол дахь парламентын сонгуулийн асуудал: онол, таамаглал. УБ., 1995 он

²³ Сонгууль -2000" сэтгүүл. УБ., 2000

²⁴ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 1996, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2010, 2011 онуудад нэмэлт өөрчлөлт оруулав.

асуудал юм.

Мөн холимог сонгуулийн тогтолцоог хэрэглэснээр Монгол улсад олон жижиг намууд төрд орж ирэх боломжийг олгож, намуудын өрсөлдөх боломж, жижиг намууд нэгдэж, намуудын төлөвших үйл явц үргэлжилсээр, эвслийн Засгийн газрыг бүрдүүлдэг. Нөгөө талаар хэтэрхий олон жижиг намууд нь үзэл бодлын зөрчилдөөн үүсгэж, эвслийн Засгийн газар байгуулсны дараа жижиг намуудын дунд байр суурь, ашиг сонирхлын зөрчилдөөн бий болж Засгийн газар удаа дараа солигдох, улс төрийн тогтвортой байдал алдагдах зэрэг сөргөөр нөлөөлөх байдал ажиглагдаж байна. Эвслийн Засгийн газрын талаар Монгол улсын Үндсэн хуулинд ямар нэг эрх зүйн зохицуулалт байдаггүй нь бүр ч мухардалд хүргэж болзошгүй юм.

Сүүлийн жилүүдэд Монголын сонгуулийн үйл явц, улс төр болон сонгуулийн практик байдлын асуудлаар олон нийтийн санаа бодлын талаар судалгааны байгууллага, гадаад улсуудын төслөөр хийгдэж үр дүн нь гарч хэвлэгдэн нийтлэгдэж байна.²⁵

Монголын ардчиллын үйл явцыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Соросын сан, ХБНГУ-ын Конрад Аденауэрын сан, Фридрих Эбэртийн сан, Ханс Зайделтийн сан, АНУ-ын Азийн сан, Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн зэрэг олон улсын байгууллагууд сонгуулийн эрх зүйн орчин, сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох олон удаагийн хурал, хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, тодорхой судалгаа шинжилгээний хөтөлбөрийг санхүүжүүлсээр байна.

Мөн Монголын "Нийслэлийн дүр төрх" хэмээх Улаанбаатар хотын сонгогчдыг хамруулсан судалгаанаас харахад Монголд ардчилсан чөлөөт сонгууль явуулахын тулд нэн даруй ямар асуудалд анхаарвал зохистой эсэх талаар судалгаанд оролцогчдын 47.4 хувь нь хуулийг хатуу мөрдөх, 42.6 хувь ил тод байдлыг хангах, 37.4 хувь нэр дэвшигчдийн шалгуур үзүүлэлтийг өндөр болгох гэх зэргээр хариулсан байна. Харин сонгож авсан арга, шийдлийн талаар хуулийг хатуу мөрдөх 18.5 хувь, ил тод байдлыг хангах 16.7 хувь, нэр дэвшигчдийн шалгуур үзүүлэлтийг өндөр болгох, намгүй тогтолцоог бий болгох 11 хувь зэрэг арга шийдлүүд бусад асуудлыг бодвол харьцангуй өндөр хувьтай байгаа нь анхаарал татах асуудал юм.

Хүснэгт №4 Ардчилсан чөлөөт, шударга сонгууль явуулахад хийж гүйцэтгэх зүйл²⁶

Хийж гүйцэтгэх алхам	Сонгож авсан арга шийдлийн хувь	Саналаа илэрхийлсэн оролцогчдын хувь
Хуулийг хатуу мөрдөх	18.5	47.4
Ил тод байдлыг хангах	16.7	42.6
Нэр дэвшигчдийн шалгуур үзүүлэлтийг өндөр болгох	14.6	37.4
Намгүй тогтолцоо	11.0	28.1
Нэр дэвшигчийг олон нийтийн оролцоотой дэвшүүлдэг болох	8.0	20.4
Сонгогчдын улс төрийн идэвхи, оролцоог дээшлүүтэх	7.7	19.6
Сурталчилгааг хуулийн хүрээнд зохион байгуулах	6.1	15.6
Сонгогчдын боловсролыг дээшлүүтэх хөтөлбөр хэрэгжүүлэх	5.2	13.2
Сонгуулийн мажоритар тогтолцоо	3.8	9.8
Сонгуулийн холимог тогтолцоо	3.7	9.4
Сонгуулийн пропорциональ тогтолцоо	3.4	8.8
Бусад	1.3	3.3

Энэхүү судалгаанаас Монгол улсын сонгуулийг зохион байгуулах аргыг боловсронгуй болгоход дан ганц сонгуулийн тогтолцоонд буруу өгөхдөө бус холбогдох бүхий л асуудлуудыг

²⁵ Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. УБ., ШУА-ийн ФСЭЗХ. 2007., Монголчууд социологийн судалгаанд. УБ., ШУА-ийн ФСЭЗХ. 2007., Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., ШУА, ФСЭЗХ. 2008 харна уу.

²⁶ Нийслэлийн сонгогчдын дүр төрх. Судалгааны тайлан. ШУА-ийн ФСЭЗХ. УБ., 2012
Д.Баасансүрэн. "Сонгуулийн кампанийн технологи" УБ., 2013

цогцоор нь авч үзэж, хэрэгжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна. Гэхдээ Монголын өнөөгийн сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох нь олон талтай нарийн төвөгтэй үйл явц бөгөөд сонгуулийг шударга явуулах бүхий л нөхцлийг бүрдүүлэх, сонгуулийн компани ажлыг явуулахад гарч буй алдаа завхралыг арилгах, улс төрийн бодлого, эрх зүйн боловсронгуй арга механизмыг оновчтой авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Эцэст нь дүгнэхэд: Монгол улсад парламентат ёс, түүний институц бүрэлдэн тогтож засаглалыг хуваах зарчим хэрэгжиж байгаа ч эерэг сөрөг олон хүчин зүйлийн улмаас нийгмийн амьдралд шийдвэрлэх асуудлууд тулгарсаар байна. Сүүлийн жилүүдэд Монголын ард түмэн төр, улс төрийн тогтолцоо, улс төрчдөд итгэх итгэл буурч, сонгогчид улс төрийн намуудаас зайлсхийх, төр засаг, улс төрийн хүрээнийхний авилгалд автсан, амиа хичээсэн, хариуцлагагүй байдал, нийгэмд шударга бус ёс байдал улам газар авч байгаа зэрэг нь Монголд ардчиллын үндсэн зарчмууд алдагдаж, ардчилал бэхжээгүй, гажуудаж байгааг харуулж байна.

Гэхдээ Монгол улс ардчиллын замд эргэлт буцалтгүйгээр орж ардчилсан сонгуулийг явуулаад 22 жил өнгөрч улс төрийн ардчиллын зарчмууд, үнэт зүйлсийг өөрийн орны онцлогт тохируулан хэрэглэх талаар нилээдгүй дэвшилтэт амжилтанд хүрсэн бөгөөд энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөөний үзэл баримтлалд тулгуурласан ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлан гаргасан. Мөн эрх зүйт төр, иргэний нийгэм төлөвшиж, чөлөөт, бүх нийтийн сонгуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн ИТХ-ыг сонгодог болж олон намын тогтолцоо тогтож, олон ургальч үзэл дэлгэрсэн гэж Монголын эрдэмтэн судлаачид дүгнэн үздэг.

Мөн аливаа улс орон аль нэг тогтолцоог муу гэж халж, сайн гэж шилж сонгохоос урьдаар өөрийн орны онцлогт тохирсон сонгуулийн тогтолцоог сонгон авсны дараа сонгуулиа зөв, шударга зохион байгуулах механизмуудыг олж тогтоон ажиллуулах нь хамгийн зөв сонголт юм. Мөн тухайн тогтолцооны сул талуудыг засаж, сайжруулан, оновчтой арга замыг өөрсдөө эрэлхийлэх нь зүйтэй. Сонгуулийн тогтолцоог өөрчилснөөр сонгуультай холбоотой бүхий л асуудал шийдэгдэхгүй бөгөөд сонгуулийн тогтолцоо нь тухайн сонгуулийн үр дүнг гаргах арга бөгөөд эерэг, сөрөг асуудлын аль аль бий учраас дан ганц сонгуулийн тогтолцоонд буруу байна гэж ойлгох нь өрөөсгөл ойлголт юм. Дэлхий нийтээр сонгуулийн сайн тогтолцоог өнөө хүртэл эрэлхийлсээр байна. Ийм учраас улс төрийн намуудын төлөвшилт, сонгуулийн кампанит ажил, намууд, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа, сонгуулийн хууль, сонгуулийн санхүүжилтийн асуудал, сонгогчдын бүртгэл судалгаа, сонгуулийн шат шатны байгууллагын үйл ажиллагаа, түүнд ажиллаж буй ажиллагчдын хариуцлага, сонгогчдын боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагын тэнцвэртэй, үнэн бодит мэдээлэл хүргэх зэрэг сонгуулийн бүхий л үйл явц, цогц асуудлуудад үр дүнтэй хяналт тавьж эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгаж хэрэгжүүлэх нь зүйтэй.²⁷

²⁷ Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем. эрэл шийдэл. УБ., 2012

АШИГЛАСАН НОМ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2011
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. УБ., 2005
4. И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ., 1975
5. А.Жамбал Монгол улс дахь сонгууль сонгуулийн шинэ тогтолцоо. УБ., 2000
6. Монгол улс дахь сонгууль. сонгуулийн шинэ тогтолцоо. Монгол улсын ШУА, ФСЭХ. УБ., 2000
7. Б.Чимэд. Сонгуульд суралцахуй. /тогтолцоо, үйл явц, эрх зүй/ УБ., 2008
8. Сургалт судалгааны прогноз төв. Улс төр ба иргэдийн оролцоо. УБ., 2010
9. Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл шийдэл. УБ., 2012
10. Д.Баасансүрэн. Сонгуулийн компанийн технологи. УБ., 2013
11. 山东大学当代社会主义研究所. "当代世界社会主义问题" [J]. 山东省, 济南市: 1990年. №2
12. 山东大学当代社会主义研究所. "当代世界社会主义问题" [J]. 山东省, 济南市: 1990年. №4
13. 中国蒙古国研究会. "蒙古国研究"[J]. 呼和浩特: 1999年, 2000年。
14. 中国社会科学院. "当代亚太"[J]. 北京市: 2006年. №3
15. 吉林大学. "东北亚论坛". [J]. 吉林省. 长春市: 2001年. №2
16. 吉林大学. "东北亚论坛". [J]. 吉林省. 长春市: 2005年. №5
17. Сонгууль -2000" сэтгүүл. УБ., 2000
18. Монгол улсын ШУА-ын ОУСХ. Герман: судалгаа, мэдээлэл. УБ., 2005
19. Юлиана Петренко. Журнал о выборах. М., 2013. №4
20. Ж.Ядамсүрэн. Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон улсын бага хурлын эмхтгэл. УБ., 2002
21. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009
22. Нийслэлийн сонгогчдын дүр төрх. Судалгааны тайлан. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2012